БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

# ЗАХИРАМЖ

1993 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Мэргэжлийн оношилгоо, зөвлөгөө өгөх төв байгуулах тухай

1.Хөдөлмөрийн зах зээлд чадвартай, авъяаслаг, мэргэжлийн боловсон хүчний эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа энэ үед хувь хүнийг таньж мэдэх, авъяас чадварыг нь нээн илрүүлэх зорилготой мэргэжлийн байгууллага шаардлагатай байгааг харгалзан нийслэлд Мэргэжлийн оношилгоо, зөвлөгөө өгөх төвийг 1993 оны 3 дугаар сарын 10-наас байгуулж, төвийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2.Тус төвийн 1993 оны төсвийг 877,7 мянган төгрөгөөр баталж, Гадаадад ажиллах хүч гаргасаны төлбөрөөс санхүүжүүлж, хяналт тавьж ажиллахыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн хэлтэс /н.Баатар/-т даалгасугай.

3.Тус төвийн төсвийн сарын цалингийн санг 9,9 мянган төгрөгөөр тогтоосугай.

4.Оросын Холбооны Улсын Свердловск мужийн захиргааны Хөдөлмөр эрхлэлтийн төвөөс хүний сэтгэл зүй-физиологийн байдлыг оношлох аппаратыг программ хангамжийн хамт худалдан авахад шаардлагатай барааг захиалгын дагуу хотын барааны сангаас гаргахыг Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс /н.Жигжидсүрэн/-т зөвшөөрсүгэй.

5.Тус төвийг мэргэжлийн удирдлага, ажиллах байраар хангаж ажиллахыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн хэлтэс /н.Баатар/, Нийслэлийн Шинжлэх ухаан боловсролын газар /н.Чимэддорж/-т үүрэг болгосугай.

6.Уг төвийн эрхлэгчээр П.Баасанцэрэнг томилж сарын цалинг 5100 төгрөгөөр тогтоосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА Д.БААСАНДАВ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА

Нийслэлийн Засаг даргын А/27 тоот захирамжийн хавсралт

# МЭРГЭЖЛИЙН ОНОШИЛГОО, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ТӨВИЙН ДҮРЭМ

## Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Мэргэжлийн оношилгоо, зөвлөгөө өгөх төв нь нийслэлийн төр захиргааны байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, сургалтын байгууллагуудтай хамтран Улаанбаатар хотын иргэдэд мэргэжлээ зөв сонгох, аж ахуйн нэгжүүдэд мэргэжлийн боловсон хүчнээ шилж сонгож авахад нь шинжлэх ухааны үндэслэлтэй мэргэжлийн зөвлөгөө өгөх ба ерөнхий боловсролын сургуулиудад ажиллаж байгаа сэтгэл зүйчдийг удирдан зохион байгуулж тэдний хүч бололцоогоор сурагчдад мэргэжлийн баримжаа тодорхойлох ажлыг эрхлэх зорилт бүхий төсөвт байгууллага байх болно.

1.2. Мэргэжлийн оношилгоо, зөвлөгөө өгөх төв нь Монгол улсын хууль болон бусад эрхийн актууд Нийслэлийн Засаг даргын захирамж, түүнчлэн энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Мэргэжлийн оношилгоо, зөвлөгөө өгөх төв нь Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр байгуулагдах бөгөөд түүний өмнө ажлаа хариуцан тайлагнана.

1.4. Мэргэжлийн оношилгоо, зөвлөгөө өгөх төв нь Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хүн амын бодлого, хөдөлмөрийн хэлтэс, Шинжлэх ухаан боловсролын газрын удирдлага чиглэлийн дагуу ажил үйлчилгээгээ явуулна.

1.5. Төв нь хуулийн этгээдийн эрх эдэлж, үүрэг гүйцэтгэх бөгөөд эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана. Түүнчлэн тогтоогдсон журмаар хийгдсэн тэмдэг хэрэглэх ба харилцах данстай байна.

1.6. Төвийн эрхлэгчийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилж, өөрчилнө.

1.7. Төвийн ажилтнуудыг эрхлэгчийн тушаалаар ажилд томилох ба өөрчилнө.

## Хоёр. Төвийн үүрэг.

2.1. Ажил эрхлээгүй хүмүүс, цомхотголд орсон болон шинээр хөдөлмөрийн зах зээлд шилжин ирж байгаа ерөнхий боловсролын сургууль төгсөгчид, мэргэжлээ солих хүсэлтэй иргэдэд шинжлэх ухааны үндэслэлтэй мэргэжлийн зөвлөгөө өгнө.

2.2. Мэргэжлийн оношилгоо, зөвлөгөө өгөх төвийн болон дүүргүүдийн хөдөлмөрийн байгууллагад ажиллах мэргэжлийн зөвлөгчдийг сонгох, мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлэх, сургалтыг зохион байгуулах ба ажлын чанар үр дүнд нь хяналт тавина.

2.3. Мэргэжлийн баримжаа тодорхойлохоор гаргасан мэргэжлийн оновчлол, мэргэжлийн зөвлөгөөний орчин үеийн оло[illegible]той аргачлалуудтай танилцан судалж, өөрийн орны нөхцөлд тохируулан ашиглах шинэлэг хувилбаруудыг боловсруулан практик үйл ажиллагаанд хэрэгжүүлнэ.

2.4. Үйлдвэр аж ахуйн газруудад тусгайн мэргэжлийн мэргэжлийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан гаргах тэдэнд мэргэжлийн боловсон хүчнээ сонгон авахад нь туслана.

2.5. Ерөнхий боловсролын сургуулиудад ажиллаж байгаа сэтгэл зүйчдийг удирдан чиглүүлж гарын авлага материалаар хангах тэдний хүч бололцоогоор сурагчдын мэргэжлийн баримжааг бага насанд нь тодорхойлон хэрэгжүүлэхэд анхааран ажиллана.

Гурав. Төвийн эрх.

3.1. Мэргэжлийн оновчлол, зөвлөгөө өгөхөд шаардлагатай мэдээ материалыг дүүрэг болон албан байгууллага, үйлдвэр аж ахуйн газруудаас гаргуулна.

3.2. Дүүргүүдийн хөдөлмөрийн байгууллагад ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн ажилд хяналт тавьж шалгах ба заавар зөвлөмж өгнө.

3.3. Улсын үйлдвэрийн газар, хувиараа эрхлэх аж ахуй, хоршоо, компани, иргэдтэй урьдчилан тохиролцсоны үндсэн дээр тэдний хүсэлтээр төлбөртэйгээр судалгаа шинжилгээ хийж түүнийхээ үр дүнг тайлагнаж хэвлэн нийтлэх ба сурталчилна.

Дөрөв. Төвийн үйл ажиллагааг зогсоох

4.1. Мэргэжлийн оновчлол, зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг зогсоох, өөрчлөх, татан буулгах асуудлыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэнэ.